

МОНГОЛД ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫГ ҮНДЭСЛЭГЧ, ТӨРИЙН ШАГНАЛТ, АКАДЕМИЧ ШАГДАРЫН ЦЭГМИД АГСНЫ НАМТАР, ШИНЖЛЭХ УХААНД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР (1922-2004)

BIOGRAPHY AND CONTRIBUTION TO SCIENCE OF ACADEMICIAN. TSEGMID SHAGDAR (1922-2004), THE FOUNDER OF THE GEOGRAPHIC SCIENCE IN MONGOLIA AND THE STATE AWARD RECIPIENT



Монголд газарзүйн шинжлэх ухааныг үндэслэгч, төрийн шагналт, академич Шагдарын Цэгмид нь 1922 он буюу XVI жарны харагчин гахай жилийн өвлийн сүүл сарын шинийн таванд Нийслэл хүрээ (*одоогийн Улаанбаатар хот*)–нд жирийн ард Шагдар, Чимид нарын ганц хүү болон мэндэлжээ. Тэрээр Нийслэл хүрээнд байрлах Оросын консулын харъяа 10 жилийн дунд сургуульд суралцан найм дугаар ангиасаа орос хэлний орчуулагчийн зургаан сарын курсэд элсэн суралцаж төгссөний дараа 1939–1940 онд “Архин завод”–ын орчуулагчаар хөдөлмөрийн гараагаа эхэлж, 1940–1941 онд Сангийн яаманд хэлмэрч, орчуулагчаар ажиллаж байсан. 1941 онд Шинжлэх Ухааны Хүрээлэн (ШУХ)–ийн Газарзүйн тасагт дагалдан судлаачаар орж Оросын эрдэмтэн Э.М.Мурзаев, хөрс судлаач Н.Д.Беспалов нарын удирдлаган дор Монгол орны баруун хязгаар Алтай Таван Богд хүртэл хээрийн судалгаанд оролцсоноор газарзүйн мэргэжилтэн болох анхны гараагаа эхэлжээ. 1942–1947 онд ЗХУ–ын Москва хотын М.В.Ломоносовын нэрэмжит Улсын Их Сургуулийн Газарзүйн факультетыг газарзүйч, дунд сургуулийн багш мэргэжлээр төгсөж, 1951 онд Оросын нэрт эрдэмтэн, академич К.К.Марковын удирдлаган дор “Хэнтийн уулархаг орны физик газарзүйн тодорхойлолт ба эртний мөстөл” сэдвээр газарзүйн ухааны дэд доктор (Ph.D), 1972 онд “Монгол орны физик газарзүйн мужлал” сэдвээр шинжлэх ухааны доктор (Sc.D)–ын зэрэг хамгаалсан. Тэрээр 1962 онд ШУА–ийн сурвалжлагч гишүүн, 1965 онд ШУА–ийн жинхэнэ гишүүн академич цол хүртжээ.

Академич Ш.Цэгмид 1951–1953 онд ШУХ–ийн Газарзүйн тасгийн эрдэм шинжилгээний ажилтан, 1953–1956 онуудад Ус цаг уурын хорооны дарга, 1955 онд Монгол улсын их сургуулийн газарзүйн тэнхимийн эрхлэгч, 1957 онд Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргын ажлыг хавсран гүйцэтгэж байсан.

Тэрээр 1955 онд улсдаа газарзүйчдийг бэлтгэхийн чухлыг анзаарч, газарзүйн багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх зорилгоор Монгол Улсын Их Сургуулийн газарзүйн тэнхимийг байгуулсан бөгөөд тус тэнхимийнхээ анхны эрхлэгчээр нь ажиллаж газарзүй, эдийн засгийн ангиудад ерөнхий газарзүйн хичээл зааж газарзүйн мэргэжлийн багш нарыг бэлтгэх эхлэлийг тавьсан юм. Газарзүйн сургалтын үйл хэрэгтэй холбоотойгоор түүнд 1957 онд доцент, 1962 онд профессор цол олгосон юм.

1961–1962 онд ШУА–ийн Байгалийн ухааны хүрээлэнгийн газарзүйн тасгийн эрхлэгч, 1962–1988 онд Газарзүй–Цэвдэг судлалын хүрээлэнгийн анхны захирлаар томилогдон 24 жил тасралтгүй удирдсан юм.

Мөн тэрээр 1975–1988 он хүртэл Шинжлэх Ухааны Академийн дэд ерөнхийлөгч, 1988–2002 онуудад ШУА–ийн Газарзүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, зөвлөхийн ажлыг тус тус хийж байв.

Академич Ш.Цэгмид физик газарзүйн шинжлэх ухааны салбарт геоморфологи, эртний газарзүй, ландшафт судлалын чиглэлээр голлон ажиллаж байсан. Анхны бүтээл нь 1953 онд “Хэнтийн уулархаг орны физик газарзүй ба эртний мөсдөлийн тухай тодорхойлолт” нэртэйгээр хэвлэгдсэнээс хойш 1953 онд “Манай эх орон”, 1957 онд “БНМАУ–ын шинжлэх ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл”, 1957, 1963, 1969, 1972 онуудад “БНМАУ–ын физик газарзүй”, 1979, 1983, 1986 “БНМАУ–ын физик газарзүй” (нэрээр 2 удаа хэвлэгдсэн), 1987, 1989, 1995 онуудад “БНМАУ–ын газарзүй (дунд сургуулийн долдугаар ангид үзэх сурах бичиг)”, 1965 онд “Монгол орны дорнод хэсгийн ландшафт ба байгалийн мужууд”, 1969, 1972 онуудад “Монгол орны физик газарзүй”, 1980 онд “Сэлэнгийн сав нутгийн байгалийн нөхцөл, нөөц баялаг”, 1981 онд “Монгол орны ойт хээрийн ландшафтын тополог судалгаа”, 2001 онд “Манай дэлхий”, 2002 онд “Санаанд үлдсэн хэсэг бусад зүйл (дурсамж)”, 2003 онд “Газарзүйн шинжлэх ухаан Монголд” зэрэг бие даасан болон хамтын нэгэн сэдэвт бүтээлүүдээ олны хүртээл болгож, 30 гаруй ном, атласыг редакторлаж, 100 гаруй илтгэл, өгүүллийг гадаад, дотоодын сэтгүүлд хэвлүүлж, газарзүйн шинжлэх ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд физик газарзүйн онолын судалгааны талаарх бүтээлүүдийн дийлэнх нь орос хэл дээр бичигджээ. Эдгээр бүтээлүүдээс “БНМАУ–ын газарзүй” 1957 онд хэвлэгдсэн анхны сурах бичиг нь ерөнхий боловсролын сургуулиудын үндсэн сурах бичгүүдийн нэг болж нийтдээ 11 удаа хэвлэгдсэн бөгөөд тус бүтээлээрээ 1984 онд “Монгол Улсын Төрийн Шагнал” хүртсэнээс гадна түүний редакторласан “Монгол орны физик газарзүй” бүтээл нь төр засагт өндрөөр үнэлэгдэж “XX зууны Шилдэг Бүтээл”–ээр шалгарч байсан.

Академич Ш.Цэгмид нь ландшафтын чиглэлийн анхны судалгааг 1962–1963 онуудад Монгол орны дорнод хэсэгт явуулж судалгааныхаа үр дүнгээр “Монгол орны дорнод хэсгийн ландшафт ба байгалийн мужууд” нэгэн сэдэвт бүтээлээ 1965 онд хэвлүүлсэн. Тус судалгааныхаа үр дүнд тулгуурлан Монгол орны ландшафтын тухай өөрийн үзэл баримтлалыг тодорхойлж ландшафтыг ангилан зураглах анхны оролдлогыг хийж, ландшафтад тулгуурласан байгалийн мужлал үйлдэн, тодорхойлолтыг өгсөн байна. Мөн тэрээр 1969 онд Монгол орны физик газарзүйн анхны гурван шатлалт мужлалтыг үйлдэж Монгол орны хэмжээнд Хангай, Хэнтийн уулархаг их муж, Алтайн уулархаг их муж, Монголын дорнод талын их муж, Говийн их муж гэсэн дөрвөн их муж, 11 муж, 27 тойрог ялгасан юм. Физик газарзүйн энэхүү мужлал нь ландшафт, геоморфологи, хөрс, ургамалжилт зэрэг дунд масштабын байгалийн нөхцөлийн цуврал зургууд зохиох суурь материал болсноороо газарзүйн шинжлэх ухааны хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан нь өнөөг хүртэл ач холбогдлоо алдаагүй байна. Түүний ялган тогтоосон гурван шатлалт мужлал нь өмнөх мужлалын дутагдалтай талуудыг засварлан сайжруулсан шинэ хувилбар болсон төдийгүй мужлал үйлдэхдээ тодорхой зарчмыг нарийн баримталснаараа онцлог юм. Тус мужлалын хамгийн том нэгж болох их мужийг ялган тогтооход геоморфологийн шинжийг өргөрөг бүсийн шинжтэй хослуулан хэрэглэж харин муж, тойргуудыг тогтоохдоо геоморфологийн шинжийг гол болгон авч үзжээ.

Тэрээр Монгол орны дорнод хэсгийн түвшинд жижиг масштабын (1:500000), Хэнтий аймгийн түвшинд том масштабын (1:100000) ландшафтын зургийг анх удаа зохиосон бөгөөд том масштабын ландшафтын зурагт зарим ландшафтыг морфологи бүтцийн хувьд ангилах оролдлого хийсэн. Тухайлбал, мөсдөж байгаагүй нарийн хөндийн ландшафтыг намаг нэн ихтэй ба торлог дотор нь хар мод хэсэг хэсгээр буюу ганц нэгээр ургасан ёроолын урочише, намаг арай багатай ба торлог дотор нь хар мод ургаагүй дэнж бэлийн урочише, үет ургамалт нуга ба мод сөөг шугуйтай хөндийн ландшафтыг нугын нийлбэр урочише, шугуйн нийлбэр урочише гэж тус тус ялгасан байна. Харин бага масштабын ландшафтын зурагт Монгол орны нөхцөлд ландшафтын бүлэг ч биш, ландшафтын морфологи нэгжүүд болох урочише, нийлбэр урочише ч биш зөвхөн ландшафтууд л дүрслэгдэх ёстой гэж үзсэн байна.

Академич Ш.Цэгмид ландшафтын судалгаанд тулгуурлан хөдөө аж ахуйд зориулсан байгалийн мужлалыг анх удаа үйлдсэн юм. Зохиогчийн тэмдэглэснээр энэ мужлал нь ашиглахад хялбарыг тооцож зөвхөн нэг шатлалтай хийгдэж улмаар Монгол орны дорнод хэсэгт байгалийн 12 районыг ялган тодорхойлжээ. Тэрээр энэ үед Монгол орны 3 шатлалт мужлалын схемийг боловсруулаад байсан (Физико–географические районирование МНР, 1962) бөгөөд дээрх байгалийн мужлалаар тодорхой зорилгод захируулсан мужлал өөр байх ёстой гэсэн үндэслэлийг анх удаа гаргаж тавьсан нь шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Хожим 1981 онд Орос–Монголын эрдэмтэд хамтран Монгол орны ландшафт–типологийн мужлалын зураг, 1990 онд Монгол орны ландшафтын зураг зохиож гаргахад академич Ш.Цэгмид зохиогч болон редактораар ажилласан байна. Энэхүү зурагт уул, тал, хотгор гэсэн 3 том анги ландшафтын хүрээнд био–

уур амьсгалын шинжээр нь бүсийн шинжтэй 13 хэв шинж, 13 дэд хэв шинж, бүсийн бус 7 хэв шинжийг ялгасан юм. Харин ландшафт-типологийн мужлалын зурагт 4 их муж, 14 муж, 34 дэд муж, 354 район, 92 дэд район ялгажээ.

Нэрт газарзүйч, академич Ш.Цэгмид энэ олон ажлын хажуугаар Дэлхийн Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Энх тайвны зөвлөлийн үндэсний хороо, ЮНЕСКО-гийн Үндэсний хорооны гишүүн байж, эдгээрийн шугамаар гадаадад болон дотоодод болсон олон хурал, зөвлөгөөнд Монгол орноо төлөөлөн оролцож байсан. Ялангуяа ЮНЕСКО буюу НҮБ-ийн Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын ерөнхий бага хуралд 1964 оноос эхлэн олон жил дараалан оролцож, өөрийн улсын энэ салбарт баримтлах байр суурь, шинжлэх ухаан, боловсрол, соёлын олон асуудлаар дэмжлэг туслалцаа авах асуудлыг тавьж, шийдвэрлүүлж байжээ. Мөн 1976–1980 онуудад Монголын Шинжлэх ухааны ажилтны холбооны дарга, 1975–1987 онуудад Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Эрдмийн зэрэг, цол олгох комиссын нарийн бичгийн дарга, 1975–1987 онуудад Төрийн шагналын хорооны нарийн бичгийн дарга, 1978–1987 онуудад Монгол-Японы нийгэмлэгийн даргын ажлыг гүйцэтгэсэн ба тус нийгэмлэг нь Монгол, Япон хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтооход үнэтэй хувь нэмэр оруулсан.

Академич Ш.Цэгмидийн олон талт үйл ажиллагаа, газарзүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь төр, засгаас өндрөөр үнэлж “Ардын хувьсгалын 40, 50, 60, 70, 80 жилийн ойн медаль”, 1956, 1974 онуудад “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, 1984 онд БНМАУ-ын “Төрийн шагнал”, 1996 онд “Сүхбаатарын одон”-гоор тус тус шагнаж байжээ.

Нэрт газарзүйч, академич Ш.Цэгмид нь газарзүйн шинжлэх ухаан, боловсролын салбарт 50 гаруй жил ажиллахдаа олон арван эрдэмтэн төрүүлж, эрдэм шинжилгээний байгууллагад боловсон хүчнийг бэлтгэхэд онцгой гавьяа байгуулсан тул Монгол Улсын Засгийн Газар (2012 оны 4-р сарын 18-ны өдөр)-ын тогтоолоор ШУА-ийн Газарзүйн хүрээлэнг академич Ш.Цэгмидийн нэрэмжит болгож байсан түүхтэй.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдмийн хамт олон академич Шагдарын Цэгмид агсны 100 жилийн ойтой холбогдуулан их эрдэмтний амьдрал, оюуны бүтээлийг оюутан залуус, эрдэм мэдлэг сонирхогч хүн бүхэнд таниулах зорилготойгоор цахим дурсамж, нийтлэл түгээх, лекц, семинар эрдэм шинжилгээний хурлын тусгайлсан хэсэг зохиох зэрэг олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

*ШУА, Газарзүй, геоэкологийн хүрээлэн
Физик газарзүй, орчин судлалын салбар
2022.12.29*